



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2015 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 38.

Арвайхээр

“Стандарттай Өвөрхангай” хөтөлбөр  
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18.1.2 “ж”, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 09/02 дугаар тогтоолоор батлагдсан, Аймгийн эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 3.1.9 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Стандарттай Өвөрхангай” хөтөлбөрийг нэгдүгээр хавсралтаар, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
2. Бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг жил бүрийн төсөвт тусган хэрэгжүүлж, хяналт тавьж, үр дүнг тухай бүр тооцож, тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д. Тогтохсүрэн/-д даалгасугай.

ДАРГА



Г. ГАНБОЛД

## **“СТАНДАРТТАЙ ӨВӨРХАНГАЙ” АЙМГИЙН ХӨТӨЛБӨР**

### **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

Өнөө үед Стандартчиллын асуудал Хүнсний аюулгүй байдлыг хангах, үйлдвэрлэл үйлчилгээний зах зээлийн харилцаан дахь нэмэгдэн өөрчлөгдөж буй эрэлт хэрэгцээг хангахад чиглэгдэж байна. Монгол Улсад 6000 гаруй стандартыг мөрдөж байгаа бөгөөд эдгээрийн 40 гаруй хувь нь олон улсын түвшинд хүрсэн, 30 хувь нь заавал мөрдөх шинжтэй байна. Аймгийн хэмжээнд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгжүүд нь одоогийн байдлаар Монгол Улсад мөрдөж байгаа үндэсний болон зарим олон улсын стандартуудыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Стандарт хүн төрөлхтний үйлдвэржилтийн гурван том хувьсгалын нэг бөгөөд бараа бүтээгдэхүүн бөөнөөр үйлдвэрлэх боломж олгосон анхны алхам нь стандартчилах үйл явц юм. Стандартын үе шат хөгжихийн хэрээр бүтээгдэхүүн, үйлчилгээ өргөжин, нэг талаас чанар, нөгөө талаас хүрээлэн буй орчин, хүний амь нас, эрүүл мэндэд аюулгүй байх шалгуур үзүүлэлтийг тогтоох, баримтжуулах, мөрдөх явдал нь хамгийн чухал болсон байна. Бүтээгдэхүүн, ажил үйлчилгээнд нөлөөлдөг гол хүчин зүйл бол чанар бөгөөд түүнийг тоогоор буюу үгээр илэрхийлэгдсэн хэм хэмжээний шаардлагыг хэрэглэгчийн эрэлт хэрэгцээ, сэтгэл ханамжид нийцүүлэн оновчтой тогтоож, боловсруулсан баримт бичиг нь стандарт юм.

Түүнчлэн чанарын дэд бүтцийн чухал нэг бүрэлдэхүүн хэсэг нь стандартчилал, хэмжил зүйн байгууллагын тогтолцоо, стандарт хэмжлийн үнэн зөв нэгдмэл байдал ордог байна. Тэгэхээр стандартчилал, хэмжил зүйн байгууллагын үйлчилгээ нь хамгийн эрүүл худалдаа, шударга үнэнийг дэмжин, хүний эрүүл мэнд аюулгүй байдлын хамгаалал, цаашлаад улс орныг хөгжүүлэхэд чухал нөлөө үзүүлдэг. Олон улсын чиг хандлага нь стандарт, хэмжил зүй, баталгаажуулалт, чанар, итгэмжлэл гээд олон асуудлыг чухалчлан авч үзэж хөгжлийнхөө гарц болгон ашиглаж байгааг нэмж дурьдахад таатай байна.

### **ХОЁР. ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН СТАНДАРТЧИЛАЛ, ХЭМЖИЛ ЗҮЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**

Монгол Улсын Шадар Сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын тохируулагч агентлаг Стандартчилал, хэмжилзүйн газар нь 20 аймгийн Стандартчилал хэмжил зүйн хэлтсээр Стандартчилал, Хэмжил зүй, Итгэмжлэл, Бүтээгдэхүүн тогтолцооны баталгаажуулалт, Сорьцын хяналтын газар гэсэн чиглэлүүдээр ажиллаж байна.

Салбарын үйлчилгээ өнөөгийн байдлаар ихэвчлэн худалдаа үйлчилгээ, үйлдвэрлэлийн салбарт чиглэсэн салбар дундын шинжтэй үйлчилгээг үзүүлж байна. Өвөрхангай аймгийн эдийн засгийн тэргүүлэх салбар нь хөдөө аж ахуй, худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлал, үйлдвэрлэлийн салбар бөгөөд эдгээрийг хөгжүүлэхэд үндэсний болон олон улсын стандартыг хэрэгжүүлэх, үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, салбар бүрийн хамтын ажиллагааг сайжруулах нь чухал байна. Өнөөдөр Засгийн газраас тогтоосон заавал стандартчилагдах бүтээгдэхүүний баталгаажуулалт орон нутагт 50 хувьтай, харин үйлчилгээний баталгаажуулалтын нэр төрөр 20-25 хувь байгаа нь аймаг орон нутгийн бренд \стандарттай\ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэн хөгжүүлэх "Стандарттай Өвөрхангай" болох шаардлагатай байгааг илэрхийлсэн үзүүлэлт болж байна.

Түүнчлэн аймгийн хэмжээнд сүүлийн жилүүдэд дэд бүтэц, барилга, орон сууц, зам харилцаа хөгжихийн хирээр томоохон бүтээн байгуулалтын ажил тухайлбал дулаан болон цахилгаан станц... гм баригдахаар төлөвлөгдөж байна. Эдгээр бүтээн байгуулалтын эдийн засгийн хэмнэлт, үр өгөөжийг нэмэгдүүлэх, буруу хэмжлийн сөрөг үр дагавараас хэрэглэгчийн эрхийг хамгаалахад хэмжил зүйн гүйцэтгэх үүргийг зөв тодорхойлон гаргах шаардлагатай байна.

#### **ГУРАВ. "СТАНДАРТТАЙ ӨВӨРХАНГАЙ" АЙМГИЙН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА**

Стандартчилал, хэмжил зүйн бодлого үйл ажиллагаа нь Монгол улсын хөгжлийн стратеги, чиг хандлагад нийцүүлэн улс орон, нийгэм эдийн засгийн аюулгүй байдлыг хангаж, экспортыг нэмэгдүүлж, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд бодлогоор дэмжлэг үзүүлэх эрхэм зорилготой билээ.

Өвөрхангай аймгийн Стандартчилал, хэмжил зүйн хэлтэс нь үйл ажиллагаагаа идэвх санаачлагатай, хяналттай явуулж, салбарын эрхзүйн шинэчлэл, төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл бүрээр төрийн үйлчилгээг шуурхай, ил тод, чанартай хэрэглэгчдэд хүргэх зорилт тавин хууль тогтоомж, дээд байгууллагын шийдвэрийн биелэлтэнд хяналт тавих, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, үр дүн өгөөжийг тодорхойлох, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Энэ чиг үүргээ бусад төрийн байгууллагуудын ажил үйлчилгээтэй уялдуулан зохион байгуулах, зохицуулах "нэгдсэн удирдлага"-ыг аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх үүднээс "Стандарттай Өвөрхангай" аймгийн хөтөлбөрийг боловсруулсан болно. Сүүлийн үед стандартын талаарх төр засгаас баримталж буй бодлого нь Евро стандарт болон олон улсын дэвшилттэй стандартуудыг нутагшуулах, уламжлалт ёсыг баримталсан байгууллагын стандарт боловсруулан мөрдөж ажиллах шаардлагатай гэж үзэж байна.

## **ДӨРӨВ. “СТАНДАРТТАЙ ӨВӨРХАНГАЙ” АЙМГИЙН ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, СТРАТЕГИЙН ЗОРИЛТ**

### **4.1. Хөтөлбөрийн зорилго.**

Монгол улсын хөгжлийн стратеги, чиг хандлагад нийцүүлэн аймаг, орон нутгийн хөгжлийг эрчимтэй урагшлуулах, нийгэм эдийн засгийн аюулгүй байдлыг хангаж, үйлдвэрлэлийг хөгжүүлэх, иргэнээ ажилтай, эрүүл чийрэг, эрдэм боловсролтой болгох, зохистой зөв хэрэглээнд төлөвшүүлэх, эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх бодлогыг хариуцлагатайгаар хэрэгжүүлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо хэмжээ, нэр төрлийг нэмэгдүүлэхэд стандартчиллын хяналтын бодлогоор дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ хамтын “нэгдсэн удирдлага”-ыг хэрэгжүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

### **4.2. Хөтөлбөрийн стратеги зорилтууд.**

1. Олон улсын дэвшилтэт стандартыг төрийн болон бизнесийн байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх.
2. Иргэн, байгууллагад үзүүлэх стандартчиллын үйлчилгээг шинэ шатанд хүргэх замаар бүх нийтийн стандартын боловсролыг дээшлүүлэх.
3. Аймгийн жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэн бүтээгдэхүүний чанар, тоо хэмжээ, нэр төрлийг нэмэгдүүлэхэд стандартчиллын бодлогоор дэмжлэг үзүүлэх.
4. Хүн байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхүйц голлох үйлчилгээний салбаруудыг стандартчилахад байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоо, чадавхыг сайжруулах.
5. Аймгийн дэд бүтэц, бүтээн байгуулалттай уялдуулан эталон хэмжих хэрэгслийн нэр төрөл, тоог нэмэгдүүлэн орон нутагт хэмжлийн үнэн зөв нэгдмэл байдлыг хангах замаар иргэдийн эрхийг хамгаалах, эрүүл аюулгүй орчинд амьдрах, ажиллах нөхцлийг бүрдүүлэх, эдийн засаг нийгмийн хөгжилд дэмжлэг үзүүлэх.

### **ТАВ. “СТАНДАРТТАЙ ӨВӨРХАНГАЙ” АЙМГИЙН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ**

Хөтөлбөрийг дараах үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

- 1 - р үе шат: 2015-2017 он
- 2- р үе шат: 2017-2020 он

### **ЗУРГАА. “СТАНДАРТТАЙ ӨВӨРХАНГАЙ” АЙМГИЙН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ, АРГА ХЭМЖЭЭ**

6.1. Олон улсын дэвшилтэт стандартыг төрийн болон бизнесийн байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх:

1. Чанарын удирдлагын тогтолцоо, Байгаль орчны удирдлагын тогтолцоо, Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо /НАССР-Эгзэгтэй цэгийн аюултай байдлын шинжилгээ/, Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны стандартуудыг нэвтрүүлэх.
2. Чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэн гүйцэтгэлийн үр дүнгээ сайжруулсан байгууллага, менежерийг шалгаруулж, урамшуулдаг журам боловсруулан мөрдөх. Чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэн гүйцэтгэлийн үр дүнгээ сайжруулсан байгууллагын сайн туршлагыг бусад байгууллагад нэвтрүүлэх.
3. Байгууллагын дотоод хяналтыг тогтмолжуулж, үр өгөөжийг сайжруулах замаар байгууллагын чадавхийг дээшлүүлэх
4. “Удирдахуй+Стандарт=Үр дүн” зөвлөгөөнийг аймгийн хэмжээнд төрийн болон бизнесийн байгууллагын удирдлагуудын дунд зохион байгуулах.

## 6.2 Иргэн, байгууллагад үзүүлэх стандартчиллын үйлчилгээг шинэ шатанд хүргэх замаар бүх нийтийн стандартын боловсролыг дээшлүүлэх

1. Стандарт мэдээлэл лавлагааны төвийн үйл ажиллагааг өргөжүүлэх, иргэдийн стандарт унших судлах, мэдээлэл авах боломжийг бүрдүүлэн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх.
2. Байгууллагын стандарт боловсруулж, хэрэглэх үйл ажиллагаанд бүх талын дэмжлэг үзүүлэх /хувийн томоохон аж ахуйн нэгжийг сонгон авч хэрэгжүүлэх/.
3. Техник технологи, харилцаа холбооны шинэ арга хэлбэрийг ашиглан стандартын мэдээллийг авах боломжийг бүрдүүлэх. /мэдрэгчтэй дэлгэц бүхий самбар/
4. “Стандартчиллын талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2013 оны 64-р тогтоолыг хэрэгжүүлэх боломж нөхцлийг бүрдүүлэх.
5. Аймгийн тэргүүлэх чиглэлийн салбар, эрүүл мэндийн салбарт стандартыг түгээх, мэдээллэх “Стандарттай сар” аянг онцлог байдлаар зохион байгуулж хэвшүүлэх
6. Тухайн салбарын стандартын сургалт мэдээлэл, хэрэгжилтийг хангахад төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх.
7. “СТАНДАРТТАЙ ӨВӨРХАНГАЙ” сэдэвт радио, телевизийн цуврал нэвтрүүлэг, улирал тутмын сонинг эрхлэн гаргаж иргэдэд хүргэх

## 6.3 Аймгийн жижиг, дунд /том/ үйлдвэрлэлийг хөгжүүлэн бүтээгдэхүүний чанар, тоо хэмжээ, нэр төрлийг нэмэгдүүлэхэд стандартчиллын бодлогоор дэмжлэг үзүүлэх.

1. Орон нутгийн түүхий эд нөөцдөө түшиглэсэн үйлдвэрлэлийг дэмжин экологийн цэвэр бүтээгдэхүүн, аймгийн брэнд бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх, дотоодын хэрэгцээг хангах, улмаар экспортлох нөхцөл боломжийг бүрдүүлэх.
2. “Үндэсний тохирлын тэмдэг”-тэй бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх.
3. Орон нутгийн чанар стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч байгууллага, бизнес эрхлэгчдийг жил бүр шалгаруулж, үйл ажиллагааг дэмжих.

4. Иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлж, агаарын бохирдлын үндэс болсон гэр хорооллын утааг багасгахад байгальд ээлтэй цэвэр үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжиж, иргэдийн санаачлагыг нэмэгдүүлэх.
5. Стандартчилал, тохирлын үнэлгээнд хамрагдаагүй бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг тусгай зөвшөөрөл олгох, худалдан авах үйл ажиллагаа, орон нутгийн шилдэг бүтээгдэхүүнийг шалгаруулах зэрэг үйл ажиллагаанд оролцуулахгүй байх талаар орон нутгаас нэгдсэн чиглэл баримтлах.

6.4 Хүн байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхүйц голлох үйлчилгээний салбаруудыг стандартчилахад байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах.

1. Монгол улсын Засгийн газрын 2005 оны 127-р тогтоолоор баталсан заавал баталгаажуулалтанд хамруулах үйлчилгээг стандартчилах.
2. Үйлчилгээний салбарын мэргэжлийн холбоодтой хамтран аялал жуучлал, үсчин, гоо сайхан, нийтийн хоолны үйлчилгээний чанарыг сайжруулах үе шаттай арга хэмжээ зохион байгуулах
3. Орон нутгийн чанар стандартын шаардлага хангасан үйлчилгээний байгууллагыг жил бүр шалгаруулах, үйл ажиллагааг дэмжих.
4. Үйлчилгээний салбарын мэргэжлийн холбоодын үйл ажиллагааг дэмжих тухайн салбарын хэмжээнд мөрдөгдөж буй стандарт, зэрэглэл, тарифын зохицуулалтыг хэрэгжүүлэн ажиллах.
5. Стандартчилал, тохирлын үнэлгээнд хамрагдаагүй үйлчилгээний салбаруудыг тусгай зөвшөөрөл олгох, худалдан авах үйл ажиллагаа, орон нутгийн шилдэг үйлчилгээний байгууллага шалгаруулах зэрэг үйл ажиллагаанд оролцуулахгүй байх талаар орон нутгаас нэгдсэн чиглэл баримтлах.

6.5 Аймгийн дэд бүтэц, бүтээн байгуулалттай уялдуулан эталон хэмжих хэрэгслийг нэмэгдүүлэн хэмжлийн үнэн зөв нэгдмэл байдлыг хангах замаар иргэдийн эрхийг хамгаалах, эрүүл аюулгүй орчинд амьдрах, ажиллах нөхцлийг бүрдүүлэх, орон нутгийн эдийн засаг нийгмийн хөгжилд дэмжлэг үзүүлэх.

1. Усны нэгдсэн менежменттэй болж хүн амыг цэвэр усаар хангах, усны зөв зохистой хэрэглээнд сургах, бодит хэрэглээг баталгаат хэмжүүрээр тооцдог нөхцөл бололцоог хангах, эталон тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх.
2. Цахилгаан, дулааны эрчим хүчний зөв хэрэглээ, бодит төлбөр тооцоог баталгаатай хэмжүүрээр ижил тэгш хэмжих боломжийг бүрдүүлэх, эталон тоног төхөөрөмжөөр хангах.
3. Стандартчилал, хэмжил зүйн ажлын орчин байр (лаборатори)-ыг стандартын түвшинд хүргэх, шинэчлэх асуудлыг шийдвэрлэх

## **ДОЛОО. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД БАРИМТЛАХ ЗАРЧИМ**

1. Төр, үйлдвэрлэгч, хэрэглэгч, тэгш эрхтэйгээр оролцох
2. Нийгмийн эрх ашигт нийцэх
3. Бие даасан хараат бус байх
4. Шинжлэх ухаан, технологийн сүүлийн үеийн түвшин, практикийн ололтод тулгуурласан байх

## 5. Аймгийн хөгжил дэвшилд саад учруулахгүй байх

### НАЙМ. ҮР ДҮН

- Стандартын талаарх иргэдийн мэдлэг дээшилж зүй зохистой, зөв хэрэглээ төлөвшинө.
- Чанартай үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагын тоо, цар хүрээ нэмэгдснээр ажилтай, орлоготой иргэдийн тоо тодорхой хэмжээгээр нэмэгдсэн байна.
- Орон нутгийн үйлдвэрлэл хөгжиж, бүтээгдэхүүний тоо хэмжээ, нэр төрөл нэмэгдэж “Үндэсний тохирлын тэмдэг”-тэй бүтээгдэхүүнүүд зах зээлд худалдаалагддаг болсон байна.
- Бүтээгдэхүүний, ажил үйлчилгээний чанар сайжирч дотооддоо болон гадаадад өрсөлдөх чадвар дээшилнэ.
- Чанарын үнэлэмж сайжирч хэрэглэгчдийг чанар стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн, ажил үйлчилгээгээр хангаж ажилласан хувийн хэвшлийнхэнийг урамшуулдаг тогтолцоо буй болно.
- Чанар, стандартын талаарх төрөл бүрийн ажил, мэргэжлийн сургалт явагдсанаар мэргэжилтнүүдийн мэргэжлийн ур чадвар дээшилж ажлын бүтээмж, үйлчилгээний чанар, хүртээмж өснө.
- Чанар, стандарт, хэмжил зүйн чиглэлийн хүний нөөцийн чадавх сайжирч, стандартын хангалт, хэмжлийн үнэн зөв нэгдмэл байдал хангагдана.
- Аймаг орон нутгийн нийгэм, эдийн засгийн үр өгөөж, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөл боломж, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалахад зөв бодит хэмжилтийн тогтолцоо бүрдэнэ.

### ЕС. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, САНХҮҮЖИЛТ

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндсэн нэгж нь Стандартчилал, хэмжил зүйн хэлтэс байна.

Хөтөлбөрийн хэрэгжилтэнд дэмжлэг үзүүлэх ажлын хэсгийг аймгийн ЗДТГ-ын хэлтэс, агентлагуудын мэргэжилтнүүдийг хамруулж байгуулна.

Хөтөлбөрийн хэрэгжилтэнд шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусган шийдвэрлэнэ. /Улсын болон орон нутгийн төсөв/

Төрийн болон ТББ-ууд, хуулийн этгээд, ОУ-ын хөтөлбөр, төслийн байгууллага, стандартчилал, хэмжил зүйн салбарын мэргэжилтнүүд, орон нутгийн ард иргэд, аж ахуй нэгжийн хамтын оролцоотойгоор хэрэгжүүлнэ.

### АРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ

Хөтөлбөрт тусгагдсан зорилтын хэрэгжилтийн явц байдлыг хагас жил тутамд аймгийн Засаг Даргын зөвлөлийн хуралдаан, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд оруулж тайлагнаж байна.

Хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавих хөндлөнгийн комиссыг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулах бөгөөд комиссын дарга нь хөгжлийн бодлогын хэлтсийн дарга, гишүүдэд төрийн бус байгууллагуудын төлөөллүүд байна.

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_